

Муколизин® 30 мг/5 мл
Сироп

Бүртгэлийн дугаар:01642

Найрлага:

5 мл сироп-т (1 хэмжээс бүхий халбага):

идэвхтэй бодис: амброксолын гидрохлорид 30 мг;

туслах бодис: сорбитол, глицерол, бензойны хүчил, сахарин, гүзээлзгэний амт, цэвэршүүлсэн ус тус тус агуулагдана.

Эмийн хэлбэр: Сироп.

Фармакологийн үйлдэл: гуурсан хоолойн шүүрлийг шингэлэх ба гуурсан хоолойн намираа хучуур эдийг идэвхжүүлж цэрний ялгаралтыг хөнгөвчилнө.

Хэрэглэх заалт: Муколизиныг өтгөн цэр бүхий дараах цочмог болон хүнд явцтай архаг өвчнүүдийн богино хугацааны эмчилгээнд хэрэглэнэ.

- ⌚ Бронхын үрэвсэл
- ⌚ Ховхроход бэрхшээлтэй цэр дагалдсан бронхын багтраа
- ⌚ Гуурсан хоолой тэлэгдэх өвчин
- ⌚ Хамар залгиурын үрэвсэлт өвчний үед бронхын шүүрлийг шингэлэх зорилгоор хэрэглэнэ.

Бэлдмэлийг хэрэглэхээс өмнө зайлшгой мэдэх мэдээлэл

Цээрлэлт:

Муколизиныг бэлдмэлийн найрлага дахь бүрэлдэхүүн хэсгүүдэд хэт мэдрэг хүмүүст хэрэглэхийг цээрлэнэ.

Тусгай анхааруулга! Бронхын хөдөлгөөний эмгэгтэй өвчтөнд бронхын шүүрэл хадгалагдаж үлдэх эрсдэлтэй учир Муколизиныг болгоомжтой хэрэглэнэ.

Эмийн ба бусад харилцан үйлчлэл

Муколизиныг ханиалга намдаах эмүүдтэй хамт хэрэглэхэд ханиалгын рефлексийг дарангуйлах тул цэр гадагшлалгүй үлдэж болно. Хамт хэрэглэх шаардлага гарвал маш болгоомжтой хэрэглэнэ.

Муколизинтэй хамт хэрэглэхэд амоксициллин, цефуроксим, эритромицин зэрэг антибиотууд нь бронхын шүүрэлд нэвтрэн орж хэмжээг нь ихэсгэнэ.

Бронхын үрэвслийн шинж тэмдгийн эмчилгээнд хэрэглэдэг бусад эмүүдтэй хэрхэн харилцан үйлчилдэг эсэх нь тогтоогдоогүй.

Тусгай бүлэг өвчтөнд зориулсан анхааруулга!

Жирэмсэн ба хөхүүл үеийн хэрэглээ

Муколизиныг жирэмсэн үед (ялангуяа жирэмсний эхний 3 сар) хэрэглэхгүй. Бэлдмэл эхийн сүүнд нэвтэрдэг бөгөөд эмчилгээний тунгаар хэрэглэх үед хөхүүл нярайд бага зэрэг нөлөөлж болзошгүй.

Автомашин жолоодох болон машин механизмтай ажиллах чадварт бэлдмэлийн үзүүлэх нөлөө

Муколизин автомашин жолоодох болон машин механизмтай ажиллах чадварт нөлөөлдөггүй.

Бэлдмэлийн найрлага дахь туслах бодисуудтай холбоотой мэдээлэл
Бэлдмэлийн найрлагад сорбитол агуулагддаг учир төрөлхийн фруктоз таардаггүй хүмүүст хэрэглэхэд зохимжгүй. Учир нь суулгах болон ходоод цочрох шинж илэрч

болзошгүй. Мөн муколизины найрлага дахь глицерол нь толгой өвдөх, ходоод цочрох, суулгах шинж үүсгэж болно.

Бэлдмэлийг зөв хэрэглэхэд зориулсан мэдээлэл:

Хэрэглэх арга, тун:

Насанд хүрэгсэд болон 2-оос дээш насны хүүхдэд зайлшгүй эмчийн бичсэн жороор хэрэглэх шаардлагагүй.

Ямар нэгэн жор байхгүй тохиолдолд дараах байдлаар хэрэглэнэ.

Насанд хүрэгсэд ба 12-оос дээш насны хүүхдэд 10 мл (2 хэмжээс бүхий халбага)-р 2 удаа; 6-12 насны хүүхдэд 5 мл (1 хэмжээс бүхий халбага)-р 2-3 удаа; 2-6 насны хүүхдэд 2,5 мл (1/2 хэмжээс бүхий халбага)-р 3 удаа тус тус хэрэглэнэ.

2-оос доош насны хүүхдэд эмчийн жорын дагуу хэрэглэнэ.

2-оос доош насны хүүхдэд 2,5 мл-р 2 удаа хэрэглэнэ.

Цэрээ ховхолж чадахгүй учир 1 -с доош насны нярайд муколизинийг хэрэглэхгүй. Эмчилгээний үргэлжлэх хугацаа нь өвчний явц, хэрэглэх заалтаас хамаарч өвчтөн бүрт өөр өөр байна. Ээлж эмчилгээ 5-7 хоногоос хэтэрч болохгүй. Шингэн сайн хэрэглэвэл бэлдмэлийн үйлдэл сайжирна.

Тун хэтэрсний улмаас илрэх нөлөө

Муколизины хордлогын үед ходоод аюулхай орчмоор өвдөх, хоолой улайх, дотор муухайрах, бөөлжих зэрэг шинж илэрнэ. Ховор тохиолдолд цусны даралт унаж болзошгүй. Хордлогын үед авах анхны арга хэмжээ бол бөөлжүүлэх болон шингэн (цай, сүү) өгөх юм. Хордсоноос хойш 1-2 цагийн дотор ходоодыг угааж болно.

Өвчтөнийг хяналтанд байлгана.

Муколизин нь шээс хөөх эм болон гемодиализаар бие махбодиос сайн гадагшлахгүй.

Гаж нөлөө

Муколизины эмчилгээний үед ховор тохиолдолд хоол боловсруулах замын зүгээс дотор муухайрах, хэвлий орчмоор өвдөх; арьсаар тууралт гарах, нүүр хавагнах, халуурах, амьсгалын үйл ажиллагааны хүнд явцтай эмгэг зэрэг харшлын урвал илэрч болно. Бэлдмэлийн найрлага дахь сорбитол, глицерол зэрэг туслах бодисууд нь суулгалт үүсгэж болзошгүй.

Хадгалалт

25°C-аас доош хэмийн хуурай, хүүхэд хүрэхээргүй газар, гэрлээс хамгаалж хадгална.

Хадгалах хугацаа

Үйлдвэрлэснээс хойш 2 (хоёр) жил. Савлалтан дээрх хүчинтэй хугацаа дууссанаас хойш хэрэглэхгүй. Савлагааг нээснээс хойш 30 хоногийн дотор хэрэглэнэ.

Савлалт

100 мл-ийн шилэн болон полиэтиленетерефталат саванд 5 мл хэмжээс бүхий халбаганы хамт савлана.

Эмийн сангаас олгох журам

Насанд хүрэгсэд болон 2-оос дээш насны хүүхдэд хэрэглэх бэлдмэлийг жоргүй олгоно. 2-оос доош насны хүүхдэд хэрэглэх бэлдмэлийг жороор олгоно.

Үйлдвэрлэгч

“Балканфарма-Троян” АД 1, Крейречна гудамж, 5600, Троян, Болгария